БНМАУ-ЫН
НИЙТИЙН АЖ АХУЙ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1986 оны 3 дугаар
сарын 19-ний өдөр

№ А-76/38

Улаанбаатар
хот

Гутал засварлах цэг салбарыг
нэмэгдүүлэх тухай

БНМАУ-ын Ардын Их Хурлын II дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулганыг угтаж Улаанбаатар хотын гутал засварлах цэг салбарыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, соёлыг дээшлүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1.Гутал засварлах цэгийн нэг маягийн барилгыг батлагдсан зургийн дагуу аж ахуйн аргаар 1986 оны 5 дугаар сарын 20-ны дотор барьж ашиглалтад оруулахыг Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдлын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.ЦЭДЭВ, н.МАНДАХ, н.ОЙДОВСАМБУУ, н.ТОГОО/-нд даалгасугай.

2.Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдлын районы нутаг дэвсгэрт гутал засварын 4 цэгийг бариулахад шаардагдах 160,0 мянган төгрөгийг өөрийн хөрөнгөнөөс гаргаж өгөхийг хотын санхүүгийн хэлтэс /н.ЭРДЭМБАТ/-т зөвшөөрсүгэй.

3.Өөрийн үйлдвэрийн ажилчдын үйлчилгээнд зориулан ахуйн үйлчилгээний иж бүрэн хүлээн авах цэг, худалдааны мухлагын барилгыг 1986 оны 5 дугаар сарын 1-ний дотор барьж ашиглалтад оруулахыг Байшин үйлдвэрлэх хоёрдугаар комбинат /н.ЦЭРЭНПИЛ/-д даалгасугай.

4.Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдлын район, Байшин үйлдвэрлэх хоёрдугаар комбинатын ашиглалтад оруулах гутал засварлах цэгийн барилгын материал, тоног, төхөөрөмжийг олж нийлүүлэн тоног төхөөрөмжийг авах хөрөнгийг яамны үйлчилгээ хөгжүүлэх фондоос санхүүжүүлэхийг Материал техникийн хангамж, нормчлолын хэлтэс/н.ЦЭРЭНДЭЖИД/, Хөрөнгө оруулалт, барилга

засварын хэлтэс /н.СҮХБАТ/-т даалгасугай.

5.Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдлын районы нутаг дэвсгэрт барих гутал засварын цэгийн байршлыг дулаан, цахилгааны холболт хийж болохуйц газарт сонгон 1986 оны 3 дугаар сарын 25-ны дотор шийдэж огохийг Архитектур төлөвлөлтийн газар /н.ЖАДАМБАА/-т үүрэг болгосугай.

БНМАУ-ын Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний яамны сайд Т.ДЭМЧИГДОРЖ

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дарга С.ЛХҮНХЖАРГАЛ